



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДОА-2020/123/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775 Цахим хаяг: edi\_7855@yahoo.com



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль



Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	10
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16



БАЯНДУН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ш.БАТЖАВ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ш.Батжав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 27-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл чийрэг, зөв төлөвшилтэй, сурлагын чанараа ахиулсан, бүтээлч хүүхдийг төлөвшүүлэх”-д оршино.

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх
- хүүхдийн хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Баяндун сумын ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд AXPLORER программ хангамж ашигладаг байна.

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 857,805.1 мянган төгрөгөөс тооцон 12,867.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,059.2 мянган төгрөгөөр буюу 12,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		124.0	124.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	145,467.7	142,179.1	-3,288.6
Үндсэн хөрөнгө	1,135,314.1	1,340,454.6	205,140.5
Элэгдэл	-196,036.5	-257,953.2	-61,916.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,084,745.3</b>	<b>1,224,804.5</b>	<b>140,059.2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,084,745.3	1,224,804.5	140,059.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,084,745.3</b>	<b>1,224,804.5</b>	<b>140,059.2</b>

Авлага дансны үлдэгдэл 124.0 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 7,181.2 мянган төгрөгийн бараа материалыг актлаж данснаас хассан байна. Батлагдсан төсвөөс 493.0 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, хандиваар үнэ төлбөргүй 3,399.6 мянган төгрөгийн бөмбөг орлогод авсан байна. Ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 6,139.6 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, 105,353.0 мянган төгрөгийн спорт залны их засвар, 5,150.0 мянган төгрөгийн гал тогооны дээврийн засвар, 3,850.0 мянган төгрөгийн технологийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүн, БСУГ-аас 9,722.9 мянган төгрөгийн сурах бичиг, хандиваар насан туршийн боловсрол төвийн байрны тохижилт 65,239.2 мянган төгрөг, 1,250.0 мянган төгрөгийн морин хуур, 5,329.0 мянган төгрөгийн ширээ, сандал, 10,676.0 мянган төгрөгийн технологийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүнийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор 7,569.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 2019 оны жилийн эцсийн тайлангаар өөрчлөлт ороогүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,224,804.5 мянган төгрөг болж 140,059.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 781,755,0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 739,655.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 42,100.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 779,222.7 мөнгөн төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардал үлдсэнтэй холбоотой.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 113,687.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,325.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 112,362.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

### 1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Нийт худалдан авалтын 85,9 хувь буюу 77,2 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь ибаримт системд бүртгэгдээгүй байна. Энэ нь *үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

### 2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Тээвэр шатахууны зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 700.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь *Төсвийн тухай хуулийн 22.1 “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.” 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтуудад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

### 3.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Түлш, шатах тослох материалын зарцуулалтыг тулган шалгахад шатахууныг норм, норматив болон жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөсөн, анхан шатны баримтын бүрдэлгүй 1,325.0 мянган төгрөгийн зөрчилтэй замын хуудас байна. Энэ нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 4. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Захирлын тушаалаар ажилчдад сахилгын шийтгэл ногдуулсан байна. Шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 1,877.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### 5. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Бараа материал дансны эхний, эцсийн үлдэгдэлд 29,018.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 269.5 мянган төгрөгийн хүнсний материалыг бөөн дүнгээр тайлагнасан байна. Хөрөнгийн нэр, төрөл, үнийн дүнг тусгаагүй зөрчил илэрсэн нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

### 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй

### 2.12. Шилэн дансны мэдээлэл

Баяндун сумын ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баяндун сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Баяндун сумын ерөнхий боловсролын сургууль 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>145,467,743.51</b>	<b>142,303,182.10</b>
33	АВЛАГА	-	124,024.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	124,024.45
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>145,467,743.51</b>	<b>142,179,157.65</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>145,467,743.51</b>	<b>142,179,157.65</b>
35410	Бичиг хэргийн материал	51,489,831.04	51,697,281.04
35420	Аж ахуйн материал	88,158,412.47	84,662,376.61
35460	Хүнсний материал	269,500.00	269,500.00
35470	Бусад хангамжийн материал	5,550,000.00	5,550,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>939,277,625.86</b>	<b>1,082,501,469.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>939,277,625.86</b>	<b>1,082,501,469.87</b>
<b>392</b>	<b>Биег хөрөнгө</b>	<b>885,370,025.86</b>	<b>1,028,593,869.87</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	580,467,679.77	756,209,919.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,111,766.56)	(25,745,363.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,500,000.04)	(25,000,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	235,918,559.00	245,891,522.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(152,793,154.81)	(164,695,403.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,192,369.40	40,755,069.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,364,493.07)	(22,962,976.46)
39209	Зам, гүүрийн байгууламж	374,465.16	6,514,115.16
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(98,509.20)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31,950,650.00	31,950,650.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,748,272.40	108,748,272.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,927,109.39)	(19,110,955.63)
39217	Ном	11,414,554.00	21,137,529.31
<b>393</b>	<b>Биег бус хөрөнгө</b>	<b>53,907,600.00</b>	<b>53,907,600.00</b>
39301	Програм хангамж	340,000.00	340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(340,000.00)	(340,000.00)
39303	Бусад биег бус хөрөнгө	53,907,600.00	53,907,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>1,084,745,369.37</b>	<b>1,224,804,651.97</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,084,745,369.37</b>	<b>1,224,804,651.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,084,745,369.37</b>	<b>1,224,804,651.97</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,020,522.80	434,020,522.80
51101	Өмч: - төрийн	434,020,522.80	434,020,522.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>22,832,346.76</b>	<b>162,891,629.36</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	22,832,346.76	22,832,346.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	140,059,282.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	627,892,499.81	627,892,499.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>1,084,745,369.37</b>	<b>1,224,804,651.97</b>



### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>745,522,869.00</b>	<b>997,864,465.31</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>105,582,409.00</b>	<b>216,109,465.31</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	105,582,409.00	216,109,465.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,582,409.00	216,109,465.31
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	105,582,409.00	216,109,465.31
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>639,940,460.00</b>	<b>781,755,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	638,293,200.00	739,655,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	638,293,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	739,655,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,647,260.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,459,760.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	187,500.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	42,100,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	42,100,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>691,389,965.64</b>	<b>857,579,182.33</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>691,389,965.64</b>	<b>857,579,182.33</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	652,311,443.14	827,763,136.28
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	452,374,907.83	577,555,685.83
210101	Үндсэн цалин	328,382,143.01	444,544,084.83
210102	Нэмэгдэл	55,005,200.00	117,354,520.00
210104	Урамшуулал	44,123,464.82	15,657,081.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,864,100.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,573,416.67	74,223,316.67
210201	Тэтгэврийн даатгал	36,947,900.00	50,464,078.35
210202	Тэтгэмжийн даатгал	4,732,434.00	5,836,595.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,704,808.79	5,023,829.36
210204	Ажилгүйдлийн даатгал	926,155.88	1,095,141.03
210205	Эрүүл мэндийн даатгал	9,262,118.00	11,803,672.41
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,699,063.00	37,274,500.00
210301	Гэрэл, шахилгаан	10,838,228.00	11,576,695.00
210302	Түлш, халаалт	27,613,635.00	25,697,805.00
210303	Цэвэр, бохир ус	247,200.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,414,590.00	24,290,031.86
210401	Бичиг хэрэг	1,149,020.00	2,725,150.00
210402	Тээвэр, шатахуун	2,030,000.00	5,663,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,453,500.00	1,948,500.00
210404	Ном, хэвлэл	91,300.00	47,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	437,000.00
210406	Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,690,770.00	13,468,781.86
2105	<b>Нормативт зардал</b>	33,150,788.00	37,178,581.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	287,900.00	287,900.00
210502	Хоол, хүнс	32,862,888.00	36,709,751.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	180,930.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,590,500.00	2,046,450.00
210604	Урсгал засвар	3,590,500.00	2,046,450.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	318,000.00	492,600.00
210702	Дотоод албан томилолт	318,000.00	492,600.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,168,700.00	2,575,370.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,168,700.00	2,575,370.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	57,021,477.64	72,126,600.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	284,400.00	1,058,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,862,440.00	1,807,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,874,637.64	69,260,020.92



Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,078,522.50	29,816,046.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,941,194.00	27,283,824.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,333,634.00	26,333,824.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,177,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	429,760.00	950,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,137,328.50	2,532,222.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,137,328.50	2,532,222.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>54,132,903.36</b>	<b>140,285,282.98</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	226,000.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	226,000.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(226,000.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>54,132,903.36</b>	<b>140,059,282.60</b>



### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>639,940,460.00</b>	<b>781,755,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>639,940,460.00</b>	<b>781,755,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	638,293,200.00	739,655,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	638,293,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	739,655,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,647,260.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,459,760.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	187,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	42,100,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	42,100,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>639,940,460.00</b>	<b>781,755,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>639,940,460.00</b>	<b>781,755,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>600,738,166.50</b>	<b>749,868,349.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	452,761,499.83	580,656,900.21
210101	Үндсэн цалин	328,768,735.01	438,924,600.00
210102	Нэмэгдэл	55,005,200.00	81,807,300.00
210104	Урамшуулал	44,123,464.82	59,925,000.21
210105	Гэрээт ажлын хөлс	24,864,100.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,573,416.67	71,320,626.74
210201	Тэтгэврийн даатгал	36,947,900.00	49,356,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,732,434.00	5,740,076.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,704,808.79	4,645,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	926,155.88	1,161,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,262,118.00	10,417,950.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,699,063.00	38,453,000.00
210301	Гэрэл, цахилгаан	10,838,228.00	11,576,695.00
210302	Түлш, халаалт	27,613,635.00	26,876,305.00
210303	Цэвэр, бохир ус	247,200.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,826,070.00	10,613,300.00
210401	Бичиг хэрэг	668,000.00	668,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,030,000.00	4,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,453,500.00	1,948,500.00
210404	Ном, хэвлэл	386,600.00	388,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,287,970.00	2,818,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33,891,517.00	36,617,043.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	287,900.00	287,900.00
210502	Хоол, хүнс	32,863,617.00	34,979,147.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	740,000.00	1,349,996.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,590,500.00	3,647,000.00
210604	Урсгал засвар	3,590,500.00	3,647,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	318,000.00	492,600.00
210702	Дотоод албан томиллолт	318,000.00	492,600.00



Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,168,700.00	2,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,168,700.00	2,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,909,400.00	5,567,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,804,000.00	2,649,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,105,400.00	2,917,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,202,293.50	31,886,650.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,064,965.00	29,354,428.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,457,405.00	28,054,428.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,177,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	429,760.00	1,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,137,328.50	2,532,222.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,137,328.50	2,532,222.05
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	22,832,346.76	-	1,084,745,369.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	22,832,346.76	-	1,084,745,369.37
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	22,832,346.76	-	1,084,745,369.37
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	22,832,346.76	-	1,084,745,369.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	22,832,346.76	-	1,084,745,369.37
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	140,059,282.60	-	140,059,282.60
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	162,891,629.36	-	1,224,804,651.97



### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>781,755,100.00</b>	<b>779,222,777.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>781,755,100.00</b>	<b>779,222,777.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>780,455,100.00</b>	<b>749,868,349.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>580,660,700.00</b>	<b>580,656,900.21</b>
210101	Үндсэн цалин	438,924,700.00	438,924,600.00
210102	Нэмэгдэл	81,807,300.00	81,807,300.00
210104	Урамшуулал	59,928,700.00	59,925,000.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,582,500.00</b>	<b>71,320,626.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,356,000.00	49,356,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,806,600.00	5,740,076.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,645,400.00	4,645,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,161,200.00	1,161,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,613,300.00	10,417,950.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,053,000.00</b>	<b>38,453,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,300,000.00	11,576,695.00
210302	Түлш, халаалт	28,153,000.00	26,876,305.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,613,300.00</b>	<b>10,613,300.00</b>
210401	Бичиг хэрэг	668,000.00	668,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,340,000.00	4,340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,948,500.00	1,948,500.00
210404	Ном, хэвлэл	388,000.00	388,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	450,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,818,800.00	2,818,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>65,938,100.00</b>	<b>36,617,043.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	287,900.00	287,900.00
210502	Хоол, хүнс	64,300,200.00	34,979,147.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,350,000.00	1,349,996.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,047,000.00</b>	<b>3,647,000.00</b>
210604	Урсгал засвар	2,047,000.00	3,647,000.00
<b>2107</b>	<b>Томлолт, зочны зардал</b>	<b>492,600.00</b>	<b>492,600.00</b>
210702	Дотоод албан томлолт	492,600.00	492,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,567,900.00</b>	<b>5,567,880.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,650,000.00	2,649,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,917,900.00	2,917,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,300,000.00</b>	<b>29,354,428.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,300,000.00</b>	<b>29,354,428.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	28,054,428.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,300,000.00